

Л.ФЕЙЕРБАХ ШАШНЫ МӨН ЧАНАРЫГ ХҮНИЙСГЭЛИЙН ЗАРЧМААР ТАЙЛБАРЛАСАН НЬ

Г.Лодой- МУИС-ийн Философийн тэнхмийн профессор

Гүлхүүр үг: Шашны үүсэл, мөн чанар, хүнийсгэл, антропологизмын зарчим, шаши идеализмын холбоо

Шашны үүсэл, мөн чанарын тухай асуудлыг философийн түүхэнд янз бүрийн байр суурьнаас тайлбарлаж байсны нэг хувилбар нь хүнийсгэлийн зарчмын үүднээс асуудлыг авч үзэх арга зүйн баримтлал юм. Арга зүйн энэ баримтлалыг шашны асуудлыг тайлбарлахад хэрэглэх оролдлого хийсэн хүмүүсийн нэг нь Л.Фейербах билээ.

Гэрээр өөрийн философийн судалгааны гол зорилтоо тодорхойлохдоо: “түүний бүх бүтээл нь зөвхөн ганц зорилго, ганц сэдэвтэй холбоотой бөгөөд тэрхүү сэдэв нь шашин болон теологитой холбоотой бүхэн болно”¹ гэсэн байдаг. Шашны асуудлыг тэрбээр антроплогийн зарчмын үүднээс авч үзэхдээ хүний уг чанарын хүнийсгэлийн тухай ойлголыг хэрэглэсэн байдаг.

Шашин, сүсэг бишрэлийн үүсэл, мөн чанарыг тайлбарлахдаа эн тэргүүнээ шашны сэтгэл зүйн үндсийн асуудалд анхаарлаа хандуулж, бурхан тэнгэрийн тухай төсөөллийг хүний сэтгэл санаа, мэдрэмж, ургуулан бодохуй, зөгнөлт сэтгэмжтэй холбон үзсэн буй. Хүн бурханыг өөртөйгөө төсөөтөй загвараар хүнийсгэн бүтээсэн гэж Л.Фейербах үзэж байв. Хүн өөрийгөө ухамсарлаж эхлэхдээ юуны өмнө төрлийнхөө мөн чанарыг ухаардаг ба хүмүүн төрөлхөний мөн чанар нь оюун ухаан, хүсэл зориглол, мэдрэмжтэй байдагт оршдог бөгөөд эдгээр чанаруудаа хүн өөрөөсөө салган хийсвэрлэж, ангид орших биеэ даасан мөн чанар мэт болгосноор хүн өөрийнхөө мөн чанарыг хүнийсгэдэг ажээ. Энэхүү хүнийсгэсэн мөн чанараа биежүүлэн төсөөлсөнөөр бурханы тухай төсөөллийг бий болгодог гэж тэрбээр үзэж байлаа. “Шашин, түүний оногдохуун болж байдаг бурханы төсөөлөл бий болох онолын шалтгаан нь ургуулан бодохуй, зөгнөлт сэтгэмжтэй холбоотой”² гэж үзээд, шашин, сүсэг бишрэлийн замд хүнийг түлхэн оруулдаг гол хүчин зүйл нь хараат байдлын мэдрэмж байдаг гэж шашны үүслийн асуудлыг тайлбарлахыг Л.Фейербах гол баримтлалаа болгосон юм.

1. Л.Фейербах. Избранные филос. произведения. М., 1955. т. 2, с. 498.
2. Мөн тэнд. с. 690
3. Мөн тэнд. С.60

Шашны сүсэглэл, бишрэлийн оногдохуй нь хүнд өөрт нь байдаг боловч төрөлхийн бус шинжтэй бөгөөд “шашны орчинд хүн өөрийгөө хоёрдуулж, бурханыг өөртөө сөргүүлэн өөр зүйл мэтээр төсөөлдөг”³ ажээ. Фейербахын үзлээр, эртний хүмүүс өөрсдийн хэрэгцээг хангах арга хэрэгслийг хайж, элдвийн зовлон зүдүүрийг эдэлсний эцэст хэрэгцээгээ хангавал баярлах, жаргах, хайрлах мэдрэмжинд автаж байсны улмаас байгалийн хүчин зүйлсийг бурханчилж, бишрэн шүтэх болжээ. Шашны анхны хэлбэрүүд үүссэн гол шалтгаан нь байгалаас хараат байсан явдалтай холбоотой. Шашны тусламжтайгаар хүмүүс хараат байдлаасаа ангижрахыг эрмэлзэж оюун санаалаг, бурханчилсан хүчин зүйлд итгэхэд хүрчээ.

Хүн байгалийг хүмүүнчлэн төсөөлөхийн хирээр түүнийг бурханчилдаг гэж Фейербах үзэж байв. Байгалийн бурханчилагдсан хүчнүүд эртний хүмүүст биет бодгаль мэтээр төсөөлөгдөх болсноор байгалийн үзэгдлүүдийг эзэнтэй болгож, тэрхүү эзэн бурханыг нь бишрэн шүтэх болжээ. Эртний хүмүүсийн хувьд нар бол ердийн нар бус, харин наран бурхан болж хувирсан учраас түүнд мөргөн тахих зан үйл үүссэн байна. Ийм замаар политеист шашин үүссэн бол хүн өөрийгөө байгалаас ангижруулж нийгмийн амьтан болгохын хирээр өөрийнхөө мөн чанарыг хүнийсгэн, нэгэн эзэн тэнгэрийн дүрд оруулан шүтэн бишрэх болсноор монотеист шашны хэлбэрүүд үүссэн ажээ.

Ертөнцийн эзний тухай төсөөлөл нь хүн улс төрийн засаглалд бүрэн захирагдаж, түүний өмнө хүчин мөхөсдөж, хараат болсонтой холбоотой бөгөөд нэг хаан байдаг тул нэг л бурхан байх ёстой гэсэн төсөөлөл хүмүүст буй болжээ хэмээн Фейербах үзэж байв. Төрийн нэгдмэл засаглал үүссэн нь монотеизм үүсэх үндэс шалтгаан болсон гэсэн дүгнэлт нь үнэнд ихээхэн ойрхон юм.

Шашны ухамсар, төсөөлөлд гарч байсан өөрчлөлтүүд нь хүн өөрийгөө ухамсарлахуйд гарч байсан өөрчлөлтүүдтэй холбоотой болохыг тэрбээр тэмдэглэсэн байдаг. “Шашинд гарч байсан аливаа дэвшил нь хүн өөрийгөө улам гүнзгий танин мэдэх болсонтой холбоотой”⁴ бөгөөд шашин бол хүний амьдралын зайлшгүй байх ёстой нөхцлийн нэг учир хүн өөрийгөө танин мэдэхийн хирээр бурхан тэнгэрийн тухай төсөөлөл өөрчлөгдөх ёстой ба үүний үр дүнд далдын ер бусын хүчинд итгэх бишрэлийг хүн хүндээ итгэх, хүн хүнээ хайрлах бишрэлээр сольж болох юм гэсэн үзлийг тэрбээр тууштай баримталж байлаа.

4. Л.Фейербах. Избранные филос. произведения. М., 1955. т. 2, С.136

Шашныг хүнийсгэлийн асуудалтай холбон тайлбарлахдаа Фейербах шашин, идеализм хоёр үзэл санааны хувьд ойролцоо болохыг онцолж тэмдэглэсэн байдаг. Шашин болон идеализмийн нийтлэг төсөөтөй тал нь сэтгэхүйг ахуйгаас, оюун ухааныг мэдэрхүйгээс, ухамсрыг тээгчээс нь салган хүнийсгэж, ухамсар сэтгэхүйг биеэ даасан ер бусын хүчин болгодогт оршдог ажээ.

Түүний үзлээр, бурхан байдаг эсэх тухай асуудал нь ерөнхий ойлголт биеэ даан оршдог эсэхтэй адилхан асуудал юм. Философийн идеализм шашнаас хожуу үүсэхдээ шашны ойлголт төсөөлүүдийг оюун сэтгэхүйн төвшинд өөрчлөн боловсруулж, бүхнийг оюун санаалаг эхлэлээс тайлбарлахыг зорьдог байна. “Идеализм бол оюун ухаанжуулсан теизм юм”⁵ гэсэн буй. Ийм байр суурьнаас Гегелийн философийг авч үзэж, түүний философи нь мөхөж буй христийн шашныг философийн тусламжтайгаар сэргээх гэсэн сүүлчийн оролдлого болохыг тэмдэглэж байв.

Шашин, идеализм хоёр нийтлэг талтай боловч бас ялгаатай зүйлс байдаг бөгөөд шашны номлолд бурхан тэнгэрийг хүнээс ангид, оюун ухаанаас гадуур орших төгс бие хүн мэтээр тайлбарладаг бол “идеалист философич, теологич нар сэтгэхүйн үүднээс бурханыг үндэслэхийг хичээдэг ажээ. Идеалист философийн номлолд бурхан тэнгэрийг хүний оюун ухаантай адилтгахыг зорьдог тул бурхан тэнгэрийн тухай шашны ойлголтыг сарниулдаг байна. Үүний нэг тод жишээ бол идеалист философийн хөгжлийн оргил нь болох Гегелийн философи болохыг Фейербах онцлон тэмдэглэж байв.

Бурхан тэнгэрийг бие хүн мэтээр үздэг шашны ойлголтыг Гегелийн философи няцаасан хэдий боловч хүний сэтгэхүйг хүнээс ангид орших биеэ даасан мөн чанартай субстанцлаг ахуй болгосноороо шашны бурханы оронд шинэ хэлбэрийн бурхан буюу туйлын санааг тавьсан нь учир дутагдалтай болохыг Фейербах шүүмжилжээ.

Шашин, философийн идеализмийг шүүмжлэх явцдаа Фейербах ертөнцийг үзэхүйн шинэ хэлбэрийг боловсруулахыг зорьсон бөгөөд түүнийгээ ирээдүйн философи гэж нэрлэж байв. Түүний үзлээр, бурхан тэнгэрийг шүтэх шашны зан үйл үеэ өнгөрөөсөн бөгөөд христийн номлол нь цаг үеийн шаардлагад нийцэхээ больсныг тэмдэглээд, христосын номлолыг үгүйсгэнэ гэдэг нь түүнийг бэхжүүлэхийг оролдож буй идеалист философийг бас давхар үгүйсгэх шаардлагатай болохыг харуулж буй хэрэг юм.

Шинэ философи боловсруулахыг цаг үе шаардаж буйг тэмдэглээд ирээдүйн философи нь өмнөх үеийн ертөнцийг үзэхүйн аливаа хэлбэр, ялангуяа шашныг үгүйсгэх ёстой бөгөөд философи шашныг орлох учир цоо шинэ агуулга хэлбэртэй болох ажээ.

⁵ Л.Фейербах. Избранные филос. произведения. М., 1955. т. 2, б. Мөн тэнд. С.136

Шашны мөн чанар нь хүний мөн чанарын хүнийсгэсэн хэлбэр байдаг учир ирээдүйд шашныг орлож чадах философи нь антропологи буюу хүний тухай философийн сургаал байх ёстой гэж Фейербах үзэж байв. “Шинэ цаг үеийн гол зорилт бол теологийг задлан няцааж түүнийг антропологи болгон хувиргаж бурхан тэнгэрийг хүмүүнжүүлэх явдал мөн”⁶ болохыг онцлон анхааруулсан буй.

Түүний үзлээр, хүн судлалын ухаан нь шашнаас бурхан тэнгэрийг арилгаж, түүний оронд хүнийг тавих ёстой бөгөөд хүний бурхан хүн өөрөө байх учиртай ажээ. Шашны гол мөн чанар нь хүн бурханыг хайрлах явдал байдаг бол шинэ философийн мөн чанар нь хүн хүнээ хайрлахад оршихыг Фейербах номлож байв. Бурханыг дээдлэх шашны оронд “хүнийг шүтэн хайрлах шашныг” номлосон нь түүний философийн нэгэн онцлог юм.

Шашны мөн чанарыг Фейербах хүнийсгэлийн зарчмын үүднээс зөв тайлбарласан хэдий боловч шашны үүсэл мөн чанарыг нийгэм-соёлын хүчин зүйлстэй холбон тайлбарлахыг чухалчилж анхаараагүйд түүний философийн нэгэн дутагдал оршдог.

Ном зүй

-Л.Фейербах. Избранные филос. произведения. М., 1955. т. 2,